

## XX зууны II хагас дахь ҮНЭЛЭМЖИЙН ОНОЛЫН ХӨГЖИЛ, ХАНДЛАГА

*Б.Өлзийсайхан (Докторант)*

*МУБИС, ТНУС*

*Философи-дидактикийн тэнхимийн багш*

**Түлхүүр үгс:** үнэлэмж, үнэлэмжийн онол, позитивист хандлага, үнэлэмжийн асуудлаарх XX зууны дунд үеэс хойших хурал, хэлэлцүүлэг, ном бүтээлүүд, үнэлэмжийн чиг хандлага хүмүүнлэгийн ухааны судалгаанд, үнэлэмжүүд ба ирээдүй

XX зууны дунд үеэс өрнөдийн философичид үнэлэмж, үнэлэмжийн онолын асуудлаарх судалгааны ажлаа идэвхижүүлж эхэлсэн билээ. Хэдэн арван жил завсарласныхаа дараа хүмүүнлэгийн ухаан эргээд соёл, үнэлэмжийн салбарын дүн шинжилгээнд хандах болов. Энэ хандлага нь хүн ертөнцийг ухамсарлах үнэлэмжийн баримжаа болоод хүний зан үйлийн үнэлэмжийн чиг баримжааг бүх амьд амьтны биологийн сонголтот чанар хэмээн үзэх позитивист үзэл хоёрын хоорон дахь эсрэгцэл, харьцуулалтыг хадгалж байлаа.

XIX зууны хоёрдугаар хагас XX зууны эхээр Романтизмын эсрэг байсан Позитивизм үнэлэмжийн онолын асуудалд хоёрдмол байр суурьтай байв. Нэг талаас, түүний үндэст оршиж байсан рационалист-сциентист төрлийн сэтгэхүй нь яг таг, нарийн мэдлэгийн хил хязгаараас халин гарсан аливаа зүйлд дээрэнгүй, үл тоомсорлох хандлагыг төрүүлж байсан. Нөгөө талаас, Позитивизм нь хүн ертөнцөд хандахдаа үнэхээр, бодитоор үнэлэмжийн үүднээс ханддаг болохыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байлаа. Иймд бас үнэт зүйлийн чиг хандлагыг судалж, аксиологийн онолыг байгуулах нь зүйтэй гэдгийг ч хүлээн зөвшөөрөхөд бэлэн байв. Гэхдээ болзол нь үнэлэмжүүдийг психофизиологи, биологи-натуралист эсвэл прагматист-утилитарист талаас нь тайлбарласан тохиолдолд юм. Өөрөөр хэлбэл сайн үйлс, гоо сайхан гэх мэтийг биологийн ашиг тустай байдал, таашаал дээр үндэслэсэн психофизикийн үнэлэлт дүгнэлт, эсвэл эдийн засгийн өртөгт авчирсан буюу хамааруулсан тохиолдолд гэсэн үг<sup>1</sup>.

Энэ үеэс “үнэлэмжүүдийг шинээр үнэлэх” нөхцөл байдал дахин үүссэн. Энэ нь Баруунд бүрдсэн олоннийтийн ахуй бас соёлын хэлбэрүүдийн хямралыг илтгэсэн бөгөөд үүнийг пролетари-социалист эсвэл национал-социалист тогтолцоогоор орлуулах боломжгүй нь тодорхой болсон. Үйлдвэржсэн нийгэм постүйлдвэржсэн нийгэмээр, капитализм посткапитализмаар, модернизм постмодернизмаар солигдох тухай төсөөлөл нь саяхан ноёрхож байсан эпистемологийн структурализмыг эрс шийдэмгийгээр түлхэн холдуулж, үнэлэмжийн асуудлыг эргээд онолын судалгааны талбар дээр гаргаж ирсэн юм<sup>2</sup>.

1968 онд АНУ-д психологийн салбарын төлөөлөгч болох А.Маслоугийн “Ахуйн психологи руу” ном хэвлэгдсэн<sup>3</sup>. Тэрээр номынхоо нэг бүлгийг “Үнэлэмжүүд” гэж нэрлэжээ. Зохиогч үнэлэмжийг дэгдээхийнээс авахуулаад хүн хүртэлх аливаа амьд амьтанд онцлог байдаг сонголтот зарчим гэж тайлбарласан байна. Ийм хандлагыг тэрээр “хүний үнэлэмжийн тухай натуралист шинжлэх ухаан” гэж нэрлээд тэрээр “бид шоргоолж, морьд, модод эсвэл марс гаригийнхны үнэлэмжүүдийг судалдаг шигээ хүмүүсийн дээд үнэт зүйлс эсвэл зорилгыг судлах

1. Каган М.С. *Философская теория ценности*. Санкт Петербург., 1997. с. 26

2. *Мон тэнд.*, с. 20

3. Maslow A.H. *Toward a Psychology of Being*. Litton Education Publishing., 1968

нь үр бүтээлтэй” гэж үзэж байв. Хожим А.Маслоу позитивист хандлагыг хангалтгүй хэмээн үзэж, “үнэлэмж” гэдэг нэр томьёо өөрөө удахгүй хуучирч хоцрогдох болно гэсэн дүгнэлтийг гаргажээ. “Энэ нэр томьёо өөртөө хэт олон утгыг агуулдаг, үүний үр дүнд “холион бантан үүсдэг бөгөөд би ерөөсөө энэ үгнээс татгалзах хүслээ арай ядан барьдаг...” гэж дүгнэсэн юм.

1971 онд Нью-Йорк ба Лондон хотноо “Үнэлэмжүүд ба ирээдүй: Технологийн өөрчлөлтүүд америкийн үнэлэмжүүдэд нөлөөлөх нь” нэртэй ном хэвлэгдэн гарсан бөгөөд үүнд А.Торфлер, Н.Решер, К.Боулдинг, Ж.Гэлбрейт гэх мэт эрдэмтэд оролцжээ<sup>4</sup>.

Мөн онд Амстердамд, Нидерландын Хааны шинжлэх ухаан, урлагийн академид “Хүмүүнлэгийн шинжлэх ухаанууд ба үнэлэмжийн асуудал” сэдэвтэй олон улсын бага хурал болсон байна. Энд үндсэн хоёр сэдвийг хэлэлцүүлэхэд анхаарав. а) Хүмүүнлэгийн шинжлэх ухаануудын үйл ажиллагааны зорилго ба үр ашиг, үнэлэмжийн асуудал. б) Онолын ба түүхийн судалгааны ялгаа ба үнэлэмжийн асуудал.

Харин 1972 онд Гааг хотноо дээрх илтгэл, хэлэлцүүлгийн товхимол хэвлэгдсэн ба эдгээр илтгэлүүдийн сэдэв ба зохиогчдын бүрэлдэхүүнийг дурьдвал: К.Кюиперс (Утрехт) Хүмүүнлэгийн шинжлэх ухаанууд ба үнэлэмжийн асуудал. Х.Г.Гадамер (Гейдельберг) Үнэлэмжийн онтологи асуудал. М.Моритц (Лунд) Аксиологи ба дүн шинжилгээ. Ш.Перельман (Брюссель) Норм дүрмийг зөвтгөх нь. М.Блек (Итака, Нью-Йорк) “Фактуал” ба “норматив”. П.Лоренцен (Эрланген) Норм дүрмийг зөвтгөх тухай. Р.Мак Кеон (Чикаго) Баримт факт, үнэлэмжүүд, үйлдэл. Н.Ро-тенштрейх (Иерусалим) Үнэлэмжүүдээс ангид байдлын судалгаа.

1976 АНУ-д К.Ситарам, Р.Когделл нарын “Соёл хоорондын харилцааны үндэс” судалгаа нийтлэгджээ<sup>5</sup>. Уг судалгаа бол Өрнө, Дорно, Африк, Исламын үндэстнүүд, америкийн хар арьстнуудын үнэлэмжийн системийн харьцуулалт дээр үндэслэсэн судалгаа байв.

1977 онд Нью-Йорк хотноо үнэлэмжүүдийн өөрчлөлтийн динамикт зориулсан арван нэгдүгээр бага хурал болсон. Мөн 1989 онд болсон ээлжит бага хурлын материалуудын товхимолд сүүлийн жилүүдэд олон улс орны философичдын оролцоотойгоор явуулсан үнэлэмжийн асуудлаарх цуврал хэлэлцүүлэг, семинаруудын тухай материалууд хэвлэгджээ<sup>6</sup>.

1980-аад оны сүүлчээр АНУ-д үнэлэмжийн онолын асуудлаарх нийтлэлүүд, судалгааны ажил ар араасаа хэвлэгдсэн юм. Тухайлбал, “Олон нийтийн ба ёс суртахууны үнэлэмжүүд: хувийн ба олон нийтийн хэтийн ирээдүй”, “Нийгмийн хам сэдэв ба үнэлэмжүүд: Америкийн хэтийн төлөв”, “Соёл ба үнэлэмжүүдийн судалгаа: их сургуулиуд, сүм хийд, үндэстнүүдийн уулзалт”. 1975-1981 онуудад Финландын турку хотын их сургууль өөрийн эрдэм шинжилгээний бичгийн таван дугаараа “Үнэлэмжийн онолын судалгаанд” зориулжээ. 1986 онд Энэтхэгт олон улсын симпозиум болсон бөгөөд Өрнө, Дорнын үнэлэмж, үнэт зүйлсийн, ялгааг тусгайлан авч үзэж хэлэлцсэн байна. 1979 онд ЮНЕСКО-оос гаргадаг “Соёл” сэтгүүлийн нэг дугаарыг “Орчин үеийн ертөнцийн соёлын хөгжилд үнэлэмжийн гүйцэтгэх үүрэг” сэдэвт асуудалд зориулав. Эдгээр арван жилүүдэд үнэлэмжийн онолын ерөнхий ба тусгай асуудлуудыг судалсан философич, социологич, соёл судлаач, психологич, ёс зүйч, гоо зүйчдийн бүтээлүүд хэвлэгдсэн байна.

Социалист орнуудын философичид үнэлэмжийн онолыг марксист үндсэн дээр босгон бүрдүүлэхийг эрмэлзэж байсан юм. Үнэлэмжийн асуудал зөвлөлтөд аксиологийг “хөрөнгөтний философи”, харин үнэт зүйлийг “хуурмаг идеологийн” ойлголт гэж зарладаг байсан албан ёсоор ноёлогч марксизмтай эсрэгцэх нөхцөлд судлагдаж ирсэн. Учир нь зөвлөлтийн идеологи (үзэл суртал) нь өөрийгөө “жинхэнэ шинжлэх ухаан”, “цорын ганц шинжлэх ухаан”-ы онолд тооцож байсан бөгөөд чухам ингэснээрээ субъектив хандлагыг үл тоомсорлож, улмаар үнэлэмжийг субъективизмыг зөвтгөхүй хэмээн хүлээн авч дээрэнгүй ханддаг байлаа. К.Маркс өөрийн зарим дагалдагчдынхаа үзэл санааны талаар ёжлонгүй хэлэхдээ “Хэрэв тэд марксистууд юм

4. *Baier K, Rescher N. Values and the future: the impact of technological change on American values. N.Y-L., 1971*

5. *Ситарам К. и Когделл Р. Основы межкультурной коммуникации. “Человек”. 1992*

6. *Каган М.С. Философская теория ценности. Санкт Петербург., 1997. с.22*

бол би марксист биш!”, “өмнө нь оршин байсан бүх материализмын гол дутагдал юу вэ гэвэл бодит байдлыг зөвхөн объект хэлбэрээр, үзэх, харах хэлбэрээр авч үздэгт оршдог. Харин хүний мэдрэмжийн үйл ажиллагаа, практик гэж авч үздэггүй байсан буюу субъектив бусаар ханддаг”. Гэвч зөвлөлтийн философи марксизмын үндэс суурийг тавигчийн энэ суурь үзэл баримтлалд биш, харин В.Лениний “Материализм ба эмпириокритицизм” зохиолдоо өгүүлсэн гносеологийн үзэл санаанд чиглэж байсан. Улмаар философийг танин мэдэхүйн онолтой адилтгасан юм. Харин сталины “диамат истмат”-ын хувилбарын зарим нэг маш улангассан ортодоксчууд “жинхэнэ шинжлэх ухааны философид” онтологи, праксеологи, антропологи, соёл судлаач, мөн аксиологи ч зохистой бус хэмээж, марксист философийн гносеологийн багасган хувилбарыг үндэслэхийг эрмэлзэж байлаа<sup>7</sup>.

Америкийн эрдэмтэн А.Тоффлер “Үнэлэмжүүд ба ирээдүй” номонд “Өнөөдөр хүн төрөлхтний өмнө цаашдын хөгжлийн төрөл бүрийн, баялаг боломжууд нээлттэй байна, гэхдээ эцсийн дүнд ямар ирээдүйг сонгох нь шийдвэр гаргах үйл явцыг тодорхойлох үнэлэмжээс хамаарах болно. Харин энэ нь юунаас шалтгаалах вэ гэвэл бид хүний зан байдлыг удирддаг үнэлэмжүүдийн бүрэн цогц байдал дахь өөрчлөлтүүдийг хэрхэн ойлгож, урьдчилан таамаглаж чадахаас хамаарах болно. Одоо бол энэхүү үл үзэгдэх цогц байдал, түүнчлэн түүний хэрхэн өөрчлөгддөг тухай бидний мэдлэг туйлын больхи байна. Ер нь үнэлэмж эсвэл “үнэлэмжүүдийн систем” гэдэг нь яг юу байдаг юм бэ? Бусад үнэлэмжүүд ямар харьцаатай байдаг юм бэ?... 70 орчим жилийн өмнө М.Вебер “үнэлэмж” гэдэг ойлголтод “манай шинжлэх ухааны үгүйрсэн байдлын өрөвдмөөр үр жимс” хэмээн хандаж байсан нь өнөөдөр энэ ойлголтын нийгмийн ухаануудад эзэлдэг байр суурийн талаарх гайхамшигтай тодорхойлолт хэвээрээ байсаар байна” хэмээн бичжээ.

Философи ба бусад нийгэм хүмүүнлэгийн ухаануудад үнэлэмжийн асуудалд хандаж ирсэн байр сууриуд нь маш их ялгаатай байлаа. Дээрх номын зохиогч үнэлэмжийн талаарх хэд хэдэн хандлагыг америкийн судлаачдын бүтээлүүдээс авч үзжээ<sup>8</sup>. Тухайлбал,

- \* А.Эдель нь М.Мерфи, Ж.Берг нарын зохиосон “XX зууны Америкийн үнэлэмжүүд ба үнэлэмжийн онолууд” номын оршил нийтлэлд аксиологийн судалгааны гурван чиглэлийг онцлон ялгажээ: идеалист, натурал, прагматист<sup>9</sup>.
- \* 1920-иод оны германы аксиологийн түүхч А.Мессер түүний дөрвөн чиглэлийг онцлон тайлбарласан: феноменологийн (М.Шелер), идеалист (Г.Риккерт), идеалист-реалист (Г.Мюнстерберг), реалист (А. Штерн).
- \* М.Киссель үнэлэмжийн онолын таван төрлийг онцлон ялгажээ: натуралист психологизм, трансцендентализм, персоналист онтологизм, соёл-түүхийн релятивизм, социологизм
- \* Л.Столвич Европ, Америкийн XX зууны аксиологиос дараах урсгалыг ялгажээ: психологи, натуралист, социологи, логик семантик, тэмдэг зүй, объектив-онтологи, феноменологи, экзистенциалист, теологи.
- \* АНУ-д гарсан “Үнэлэмжийн онолын түүхэн хүрээ” гурван боть номын зохиогч В.Веркмайстер үнэлэмжийн онолыг байгуулах бүр ч олон чиг хандлагыг онцлон ялгасан байна: утилитарист эдийн засгийн, сэтгэл хөдлөл зөн совингийн, метафизик, персоналист, психолог генетикийн, феноменологи, гоо зүйн, гуманист, релятивист, эмпирик-танин мэдэхүйн, хэл шинжлэлийн гэх мэт<sup>10</sup>.
- \* Шведийн философич М.Моритц аксиологийн онолуудын дараах ангиллыг санал болгожээ:

7. *Мөн тэнд.*, с.44

8. *Baier K, Rescher N. Values and the future: the impact of technological change on American values. N.Y-L., 1971*

9. *Murphey M. G. and Berg J. (Ed.) Values and Value Theory in Twentieth-Century America. Essays in Honor of Elizabeth Flower. – Philadelphia., 1988*

10. *Werkmeister W. H. Historical Spectrum of Value Theories. V. 1-2. Lincoln, Nebraska., 1970*

Үнэлэмжийн онолууд	Танин мэдэхүйн онолууд				Танин мэдэхүйн бус онолууд	
	Объективист онолууд	Натуралист онолууд				
Үнэлэмжийн онтологи		психологийн	социологийн	хувьслын	геднионистик	
Эерэг онтологи						
Сөрөг онтологи	Х у у р м а г онтологи					

Судлаачдын үзэж буйгаар үнэлэмжийн онолын 1.5 зууны түүхийн туршид бүрдсэн үзэл баримтлалууд хэдийгээр зөрчилтэй байсан ч гэлээ үнэлэмжийн асуудлаарх ерөнхий дүгнэлтийг эерэг байсныг нь хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Тухайлбал, Үнэлэмжийн онол нь философи дотор ач холбогдлоороо гносеологитой эн тэнцэх зайлшгүй шаардлагатай сүүлчийн онолын салбар гэдэг утгаараа өөрийн гэсэн байр сууриа баталж чадсан. Мөн “мэдлэгийн социологи” (М.Вебер ба түүний сургууль) хэмээх боловсруулалт нь шинжлэх ухааны хөгжил дэвшил, үйл ажиллагаа танин мэдэхүйн үйл ажиллагааг үнэлэмжээр дамжуулснаас ихээхэн хамаардаг болохыг илтгэв. Үнэлэмжид хандах социологийн хандлага нь үнэлэмжийг “хүмүүнлэгийн ухааны өнөөгийн хэт оргилсон ба эрхэмсэг хий хоосон байдлаас чөлөөлөх хэрэгсэл” болгодог байна (Ж.Лэрд). Шинжлэх ухаануудад бүх эцсийн баримт, шалтгаанууд нь үнэлэмж рүү хандах хандалт, тэмүүлэх тэмүүлэл болж хувирдаг (А.Н.Уайтхед). Соёлыг “хэрэгжсэн үнэлэмжүүдийн ертөнц” хэмээх өргөн түгсэн төсөөлөл цаанаа шинжлэх ухаан нь соёлын салбараас түүний харьцуулагдаж ирсэн “соёл иргэншил”-рүү “түлхэгдсэн гэсэн утга санааг агуулж байв”<sup>11</sup>.

Гэтэл нөгөө талаас үнэлэмжийг хүний ахуйн мөн чанар, түүнчлэн соёлын хамгийн эрхэм үйл ажиллагаа, зан үйлийн хүч, сэтгэл оюуны цөм мөн хэмээн хүлээн зөвшөөрөх явдал нь, позитивист сциентизмын байр сууринаас төдийгүй, иррационал идеализмын байр сууринаас ч үгүйсгэгдэх тохиолдол байсан юм. М.Хайдеггер “Гуманизмын тухай захидал”-даа “ямар нэгэн зүйлийг үнэлэмж гэж тодорхойлох нь түүнийг жинхэнэ нэр хүндээс нь холдуулдаг. Яагаад гэвэл аливаа үнэлэлт дүгнэлт нь, эерэг үнэлэлт дүгнэлт байлаа ч гэсэн, субъектжуулалт байдаг бөгөөд энэ нь ахуйг онтологийн объектив шинжээс нь салгадаг. Тэгээд ч Бурханыг “дээд үнэлэмж” гэж бишрэн хүлээн зөвшөөрөх явдал бол бурханлаг оршихуйг доош хийж байгаа хэрэг мөн бөгөөд энэ нь түүний ахуйн жинхэнэ үнэнийг гээгдүүлдэг юм...” гэж дүгнэсэн. Гэхдээ М.Хайдеггерийн аксиологийн эсрэг байр суурь нь европын философид давамгайлж чадаагүй.<sup>12</sup> Учир нь ХХ зууны сүүлчээр хүний нийгмийн ахуйн бодитой, бүр ч хурц болсон зөрчилдөөн ялангуяа хүн төрөлхтний түүхэнд урьд өмнө нь гарч байгаагүй асар том хэмжээний фашистын концлагериуд, большевикуудын гулаг, японы хотууд дээр хаясан атомын бөмбөг гэх мэт нь тэдгээрийг үнэлэмжийн өнцгөөс ухамсарлахыг шаардсан. Иймд үнэлэмжийн онолын асуудлуудыг философичид идэвхтэйгээр хэлэлцүүлсэн хэвээрээ байгаад зогсохгүй, үнэлэмжийн чиг хандлага хүмүүнлэгийн мэдлэгийн тодорхой салбарууд, социологи, нийгмийн психологи, психологийн судалгааны бусад салбарууд, ёс зүй ба гоо зүй, соёл судлал, урлагийн мэдлэгт нэвтэрсээр байна.

## НОМ ЗҮЙ

1. Өлзийсайхан Б. Үнэлэмж ба үнэний тухай асуудал. Философи, эрх зүйн боловсрол ЭШБ 2013. №6
2. Каган М.С. Философская теория ценности. Санкт Петербург., 1997
3. Baier K, Rescher N. Values and the future: the impact of technological change on American values. N.Y-L., 1971

11. Каган М.С. Философская теория ценности. Санкт Петербург., 1997. с.2

12. Мөн тэнд., с.27-28

4. Maslow A.H. Toward a Psychology of Being. Litton Education Publishing.,1968
5. Stern A. Philosophy of History and the Problem of Values. The Hague.,1962

## РЕЗЮМЕ

После нескольких десятилетий перерыва гуманитарная мысль вновь обратилась к анализу аксиосферы культуры. В 1971 г. в Нью-Йорке и Лондоне вышел сборник статей "Ценности и будущее: Влияние технологических изменений на американские ценности", в котором участвовали такие выдающиеся ученые, как А. Тоффлер, Н. Решер, К. Боулдинг, Дж. Гэлбрейт и ряд других. В конце 80-х годов в США один за другим выходят фундаментальные сборники статей, посвященные таким аспектам теории ценности, как "Общественные и моральные ценности: индивидуальные и социетальные перспективы", "Социальный контекст и ценности: перспективы Америки", "Исследование культур и ценностей: встреча университетов, церквей и наций".

Остается резюмировать, что при всей пестроте и разноречивости концепций, сложившихся за полтора столетия истории аксиологии, главный итог этой истории нельзя не признать позитивным: он состоит, во-первых, в утверждении аксиологией своего места в философии как необходимой последней теоретической дисциплины, уравненной по своему значению с гносеологией.